



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 11 өдөр

Дугаар 11634

Улаанбаатар хот

“Ус сувгийн удирдах газар” орон нутгийн
өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн
газрын барилга байгууламжийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 77 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/579 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтүүдээр ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй Баянзүрх, Баянгол, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах нийт 20,616,681.18 (хорин сая зургаан зуун арван зургаан мянга зургаан зуун наян нэгэн төгрөг арван найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 6 ус түгээх байрыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (Ц.Төрхүү)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 440,000 (дөрвөн зуун дөчин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ (Ц.Төрхүү)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3. Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийхийг “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (Ц.Төрхүү)-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.БАЯРАА

